



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

ХЭРЭГЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН СТАТИСТИКИЙН ЧАНАРЫН ТАЙЛАН

2014 оны жилийн эцсийн мал тооллого



Улаанбаатар хот
2015 он

АГУУЛГА

1. Мал тооллогын товч түүх.....	4
2. Нийтлэг үндэслэл.....	5
3. Ойлголт, тодорхойлолт.....	6
4. Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарын үзүүлэлт.....	8
4.1. Үнэн бодит, найдвартай байдал.....	8
4.2. Цаг хугацаандаа байх, шуурхай байдал.....	11
4.3. Хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байдал.....	11
4.4. Нийтэд хүртээмжтэй, ил тод байдал.....	12
4.5. Нийцтэй, харьцуулах боломжтой байдал.....	12
5. Нууцлалыг хангасан байдал.....	13

Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
МАА	Мал аж ахуй
МБ	Монгол банк
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮХААЯ	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам
ХАА	Хөдөө аж ахуй
ХААТ	Хөдөө, аж ахуйн тооллого
ХХААЯ	Хүнс, хөдөө аж ахуйн яам

1. Мал тооллогын товч түүх

Мал аж ахуй нь монгол орны хувьд амьжиргааны гол эх үүсвэр болсон анхдагч үйлдвэрлэлийн салбар байсны хувьд бүртгэл, статистикийн ажил ч энэ салбараас эхлэн хөгжсөн түүхтэй. XIII зууны үед Монгол улсад хүн, малын тооллого явуулж байсан баримт түүхийн сурвалжид тэмдэглэгдэн үлдсэн байдаг.

Манжийн хараат байх үед монголд мал тооллого явуулж байсан боловч нэгдсэн тооллого хийж чаддаггүй, орон нутгийн чанартай байв. Аймаг, хошуудад янз бүрийн хугацаанд, өөр өөрсдийн шаардлага үзэмжээр мал тооллого явуулж байсан байна.

Гадаад Монголын засгийн газар 1918 онд хүн ам, малын тооллого явуулсан байна. Уг тооллого нь халхын 4 аймаг, лам, ноёд, шавь албат ардууд, сүм хийдийн малыг хамруулсан боловч Ховдын хязгаар, Дархадын хязгаар, Хөвсгөл нуур орчмын Богд гэгээний эзэмшил нутгийн мал ороогүй ажээ.

Ардын засгийн газар 1924 онд Дотоод яамны бүтцэд Тоо бүртгэлийн хэлтсийг шинээр байгуулж, мал тооллогыг үнэн зөв явуулах талаар онцгой анхаарч, тооллого явуулах, данс бүртгэлийг нэгтгэх, тушаах цаг хугацааг тогтоож, хуучин төлөөний түшмэл дээр боловсрол чадвартай тусгай түшмэлийг нэмэн томилж, ард олонд тайлбарлан таниулах ажлыг зохиосны үр дүнд анх удаа улсын хэмжээгээр хугацаа, аргачлалын хувьд нэгдсэн программтай мал тооллого явагдсан байдаг. Мал тооллогод урьд өмнө нь бүртгэгдэхгүй байсан цаа буга, илжиг, луус, өвс хадлан, тариалангийн талаар зарим нэмэлт үзүүлэлтийг 1924 оноос эхлэн оруулсан байна.

Мал тооллогыг зун, намрын улиралд буюу ихэвчлэн 8, 9 дүгээр сард явуулж байснаа 1961 оноос мал, тэжээвэр амьтдыг жилийн эцэст 12 дугаар сард тоолдог болов. Энэ хугацаа нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн жилтэй тохирдог, малын орлого, зарлагын үзүүлэлт бүрэн гарч дууссан, малчид өвөлжөөндөө бууж, хүн, малын хөдөлгөөн харьцангуй бага байдаг зэрэг давуу талтай юм. Малын хашаа байрын тооллогыг 1966 оноос, худаг, малын тэжээлийн тооллогыг 1972 оноос нэмж мал тооллоготой хамтруулан явуулдаг болов.

Ардын хувийн аж ахуйтны малыг 1959-1960 онд нийгэмчилж хоршоололд хамруулж дууссан бол 1992 онд малыг хувьчлах ажил хийгдэж дууссан билээ. Мал хувийн өмчид шилжсэнээр төлөвлөгөөт эдийн засгийн үед жилд дунджаар 23 сая толгойгоос хэтрэхгүй байсан малын тоо 2014 оны байдлаар 52 сая толгойд хүрээд байна.

2. Нийтлэг үндэслэл

Монгол улсын “Статистикийн тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 тоот тогтоолын дагуу Үндэсний статистикийн хороо жил бүрийн 12 дугаар сарын 7-ноос 17-ны өдрүүдэд мал, тэжээвэр амьтдын тооллогыг зохион байгуулан явуулж байна.

Манай улсын эдийн засагт мал аж ахуйн салбар нилээд голлох байрыг эзэлдэг бөгөөд салбарын үйлдвэрлэлийн бодит хэмжээг тооцож, тодорхойлоход малын тоо болон ашиг шимийн өөрчлөлт ихээхэн чухал юм. Мал, тэжээвэр амьтдын тооллогын дүнд үндэслэж мал, амьтдын өсөлт, бууралт, сүргийн бүтцэд гарч байгаа өөрчлөлт, мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүний хэмжээг тооцон дүн шинжилгээ хийж, цаашид хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх талаар төр засгийн бодлого боловсруулах, хэрэгжилтийг дүгнэхэд шаардагдах дэлгэрэнгүй мэдээллийг гарган авах, мал аж ахуйн салбарт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээг тооцох боломж бүрдэж байна.

Түүнчлэн манай улсын үндсэн хуулийн нэгдүгээр бүлгийн 5 дугаар зүйлийн 5-д “Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна” гэж заасан нь малыг жил бүр тоолж, бүртгэлжүүлж байх нэг үндэслэл нь болж байна.

Мал тооллогын үр дүн нь мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх, ашиг шим, үүлдэр угсааг нь сайжруулахад чиглэгдсэн төрийн бодлогыг улс, орон нутгийн түвшинд боловсруулж хэрэгжүүлэх, улмаар хүн амын өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний хэрэглээ, хангамжийг тооцох суурь мэдээллийг бүрдүүлэхээс гадна боловсруулах аж үйлдвэрийн салбарын эдийн засгийн тооцооны тулгуур үндэслэл болдгоороо ихээхэн ач холбогдолтой юм.

Мал тооллогыг жил бүр малтай өрх, ААНБ бүрийг хамруулан явуулж, тухайн оны 12-р сарын 20-25-нд урьдчилсан дүнгийн нэгтгэлийг гарган тархааж, нэгдсэн дүнг тухайн оны 12-р сарын “Нийгэм, эдийн засгийн байдлын танилцуулга”-аар хэрэглэгчдэд тархаадаг.

ҮСХ-ны даргын 2013 оны 7 сарын 1-ний өдрийн 1/84 тоот тушаалаар “Монгол улсын албан ёсны статистикийн чанарын бодлого”, “Монгол улсын албан ёсны статистикийн чанарын удирдлагын стандарт хэм хэмжээ”-г баталсан нь хэрэглэгчдийг эрэлт хэрэгцээнд нь нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хангах, чанарын удирдлагын механизмыг бүрдүүлэн нэвтрүүлэх ажлын эхлэл боллоо.

3. Ойлголт, тодорхойлолт

Малтай өрх. Малчин болон мал бүхий өрхийг нийтэд нь малтай өрх гэнэ.

Малчин өрх. Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа өрхийг хэлнэ.

Малчид. Жилийн 4 улирлын туршид мал аж ахуй эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Бодод шилжүүлэх коэффициент:

1 адуу, үхэр	– 1 бод
1 тэмээ	– 1.5 бод
6 хонь	– 1 бод
8 ямаа	– 1 бод

Бодод шилжүүлэх коэффициентийг таван төрлийн малыг нэг төрлийн малд шилжүүлэн малын өсөлт, бууралтыг гаргах, үр ашгийг тооцоход ашиглана.

Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1 тэмээ	– 5 хонь
1 адуу	– 7 хонь
1 үхэр	– 6 хонь
1 хонь	– 1 хонь
1 ямаа	– 0.9 хонь

Хонин толгойд шилжүүлэх коэффициентийг малын тэжээлийн хүрэлцээ, хангамж, бэлчээрийн даацыг тодорхойлон гаргахад ашиглана.

Нас гүйцсэн мал. Малын төрөл бүр дээр дараах насны малыг хамруулна.

Тэмээ	- 4 ба түүнээс дээш настай
Адуу	- 3 ба түүнээс дээш настай
Үхэр	- 2 ба түүнээс дээш настай
Хонь	- Тухайн жилийн төл малаас бусад насны хонь
Ямаа	- Тухайн жилийн төл малаас бусад насны ямаа

Өсвөр насны мал

Тэмээ	- Өмнөх оны төл, 2, 3 настай
Адуу	- Өмнөх оны төл, 2 настай
Үхэр	- Өмнөх оны төл

Төл мал. Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч. Малын төрөл бүр дээр нас гүйцсэн эм малыг хамруулна.

Малын тоо толгойн өсөлт. Оны эцсийн малаас оны эхний малыг хасч, малын тооны өөрчлөлтийг тоогоор илэрхийлнэ. Оны эцсийн малын тоог оны

эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж, өсөлт, бууралтыг хувиар илэрхийлнэ.

Малын өсөлтийн **орлого тал** нь төл бойжилт, **зарлага тал** нь хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол байна.

Төллөлтийн хувь. Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100 –гаар үржүүлэн тооцно.

Бойжилтын хувь. Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100–гаар үржүүлэн тооцно.

100 эхээс бойжуулсан төл. Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо. Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулж тооцно.

1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Буур	-	20-25
Азарга	-	12-15
Бух	-	35-45
Хуц, ухна	-	25-30

Том малын зүй бус хорогдолд өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас, зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг хамруулна.

Оны эхний малд том малын зүй бус хорогдлын эзлэх хувь. Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Малын хэрэглээний зарлага. Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч тооцно.

Малын хашааны хангамж. Хашааны хангамжийг тооцохдоо хашааны багтаамжийг малын тоонд харьцуулна. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг бог малын /хонь, ямааны/ тоонд харьцуулж тооцно.

Тэжээл хангамж. Тэжээлийн хангамжийг тооцохдоо тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан тооцно.

Бэлчээрийн даац. Бэлчээрийн даацыг тооцохдоо бэлчээрийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан тооцно.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх итгэлцүүр. Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Дараах итгэлцүүрийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ:

Бэлтгэсэн тэжээл	Итгэлцүүр
Гар тэжээл, хужир шүү	1.00
Үр тарианы хаягдал	0.90
Хадлан өвс	0.45
Лай	0.40
Таримал тэжээл	0.35
Даршны ургамал	0.25
Сүрэл	0.25
Төмс ногооны хаягдал	0.22

Малын тэжээлийн ангилал. Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

- Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал багтах бөгөөд бүдүүн, хүчит, шүүст гэж ангилна.
 1. Бүдүүн тэжээл - өвс, сүрэл, нэг наст ба олон наст ургамал
 2. Хүчит тэжээл - үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг
 3. Шүүст тэжээл - бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал тус тус орно.
- Амьтны гаралтай тэжээлд яс, цусны гурил зэрэг багтана.
- Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

4. Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарын үзүүлэлт

Чанарын олон талт ойлголттой холбоотойгоор **статистикийн бүтээгдэхүүний чанар нь** хэрэглэгчийн үнэлэмж, төрөл бүрийн түвшний хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлага болон тэргүүлэх ач холбогдолтой мэдээллүүдийн чанараар тодорхойлогдож байна. Мал тооллогын чанарын үзүүлэлтийг ҮСХ-ны чанарын бодлогын баримт бичигт тусгасан дараах шалгуур үзүүлэлтүүдээр тодорхойлов. Үүнд:

4.1. Үнэн бодит, найдвартай байдал

Үндэсний статистикийн хороо жил бүрийн 12 дугаар сарын 7-ноос 17-ны өдрүүдэд “Мал, тэжээвэр амьтдын тооллого”-ыг улс орон даяар зохион байгуулан явуулж байна.

Жилийн эцсийн мал тооллогын ажлыг дараах хууль эрх зүйн баримт, бичгийг үндэслэн зохион байгуулж байна. Үүнд:

1. Монгол улсын “Статистикийн тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт;
2. Монгол Улсын Засгийн газрын 224 тоот тогтоол, 2003 он;
3. “Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллого”-ын маягт, түүнийг нөхөх заавар, ҮСХ-ны даргын тушаал А/103, 2014 он.

Мал тооллогод хамрагдвал зохих иргэд, ААНБ-ыг хамруулж, мэдээллийг үнэн бодитой, найдвартай байлгах үүднээс дараах зарчмуудыг баримтлан зохион байгуулж байна. Үүнд:

- Малыг нэг бүрчлэн нүдээр үзэж, биечлэн тоолж бүртгэх;
- Өрх, аж ахуйн нэгж, байгууллагын малыг байгаа газарт нь тоолж, тухайн оршин сууж байгаа баг, хороо, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн малын данс бүртгэлд оруулах;
- Баг, сумын нутаг дэвсгэрт ялангуяа адуу, тэмээг газар дээр нь тооллогод бүрэн хамруулан, биечлэн үзэж тоолоход онцгой анхаарах;
- Мал тооллогын явцад зарим аймаг, сум, дүүргийн малтай өрх өөр аймаг, сум, дүүргийн нутагт нутаглаж харьяалах сум дүүргээс нь очиж тоолох боломжгүй бол холбогдох, аймаг, сум, дүүргийн статистикийн хэлтэстэй холбогдож, малыг нь тоолуулан, өөрийн данс бүртгэлд оруулах;
- Улс, аймаг, сумын түвшинд мал тооллогод хамрагдвал зохих нийт өрхийн 10 орчимд хувьд хяналт, үнэлгээ хийх .

Мал тооллогын ажлыг зохион байгуулахтай холбоотой асуудлаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэл, сурталчилгаа хийдэг.

- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр тооллогын хугацаанд малаа бүрэн байлгах;
- Тооллогын хугацаанд малаа байнгын харгалзах эзэнтэй байлгах.

Тооллогын баталгаажуулалт: Малтай өрх, ААНБ бүрээр маягтаар цуглуулсан мэдээллийг малчны гарын үсэг болон тамгаар баталгаажуулж авдаг.

Хяналтын тооллого: Мал тооллогын явцын хяналт, шалгалтыг ҮСХ-ноос ХХААЯ-тай хамтран маршрут гарган тухайн жилийн төсвөөс шалтгаалж 6 хүртэлх аймгийн 2-3 сумын хяналтын тоологч бүр 30-аад малчин өрхөд хяналтын тооллогыг хийдэг. Энэхүү хяналтыг мөн аймаг бүр малтай өрхийнхөө 10.0%-д дээрх зарчмаар явуулдаг.

ҮСХ-ноос тооллого, судалгаагаар гарч буй мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлыг хангах үүднээс тооллого, судалгааны мэдээлэл цуглуулахаас эхлээд хэрэглэгчид тархаах хүртэлх бүхий л үе шатанд дараах байдлаар хяналт тавьж ажилладаг. Үүнд:

Тооллогын бэлтгэл ажил, зохион байгуулалтын чиглэлээр:

- Бэлтгэл ажил;
 - Тооллогын комисс байгуулж, орон нутгийн төсвөөс мал тооллогын төсөв батлуулж, дагаж мөрдөн ажилласан эсэх

- Мал тооллогоор ажлын хэсэгт зориулсан сургалт зохион байгуулсан эсэх
- Аймгийн статистикийн хэлтсээс тооллогын мониторинг хийсэн эсэх;

Тооллогын мэдээллийн чанарын асуудлаар:

- Логикийн болон балансын алдаа
- Үзүүлэлт дутуу нөхөх
- Цэг, таслал андуурах
- Хэмжих нэгжийн алдаа
- Ангиллын код буруу оруулах
- ХАА-н сарын мэдээнээс хэт зөрүүтэй байх
- Өрхийн мэдээлэл нь өмнөх оны тооллогын мэдээллээс хэт зөрүүтэй байгаа эсэх
- Малтай болон малчин өрхийн өөрчлөлт
- Оны эхний болон оны эхний хээлтэгч мал зөрүүтэй байх
- Зарлагдсанаас хойш тоог залруулах

Графикт хугацаанд мэдээлэл дамжуулсан байдал зэрэг болно.

Мэдээллийн санг 2012 оноос эхлэн малтай өрх, ААНБ бүрээр малын тоо толгойн өөрчлөлт, малын орлого, зарлагын хөдөлгөөн, тэжээл үйлдвэрлэл зэрэг үзүүлэлтүүдийг бүрдүүлж байгаа тул өрхийн мэдээллийг хянах боломж бүрдсэн юм.

Хагас жилийн мал тооллогыг зуд, байгалийн гамшигт үзэгдлийн дараа малчдын амьжиргаа доройтдог эмзэг байдлыг бууруулж тогтвортой болгох, ингэхдээ зөвхөн даатгалд хамрагдсан малчдад зохих хэмжээний даатгалын нөхөн олговрыг олгож хохирлыг нөхөх, бэлэн мөнгө, мал олгож малчдыг бэлэнчлэх сэтгэлгээнд сургахаас зайлсхийх, даатгалын салбарын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, улмаар даатгалын компаниуд энэхүү өвөрмөц аргачлалаар малыг даатгаж олон улсын жишиг зах зээлийн зарчмаар цаашид хөгжих боломжийг нэмэгдүүлэх, зуд болон байгалийн гамшгийн үед Засгийн газрын үүрэг ачааг хөнгөвчлөх, гамшгийн хохирлыг дан ганц төрөөс хариуцах биш тодорхой хэсгийг хувийн хэвшил, олон улсын байгууллага /давхар даатгал/-ын хөрөнгийн эх үүсвэрээр нөхөх тогтолцоог бий болгох үүднээс 2006-2008 онд 3 аймаг, 2009 онд 4 аймаг, 2010 онд 9 аймаг, 2011 онд 15 аймаг, 2012 оноос бүх аймгийг хамруулж, нийт малтай өрх, ААНБ-ын 30.0 гаруй хувьд түүвэр судалгаа явуулж, үр дүнг жилийн эцсийн мал тооллогын үр дүнтэй холбон шалгаж, хэрэглэгчдэд хүргэсэн болно.

Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “л” – д Хөдөө аж ахуйн ээлжит тооллого (ХААТ)-ыг 10 жил тутам, завсрын тооллого, судалгааг 5 жил тутам” явуулна гэж заасны дагуу 2012 онд анхны тооллогыг явуулсан. ХААТ-оор ХАА-н салбарын мэдээллийг цуглуулах, цогц үзүүлэлтийг дэлгэрэнгүй байдлаар баг, хорооны түвшинд бүрдүүлэх, түүнчлэн анхан шатны засаг захиргааны түвшний талаарх үзүүлэлтүүдийг цуглуулж, мэдээллийн нэгдсэн бааз бий болж, ХАА-н түүвэр судалгааны хүрээ бэлтгэгдсэн.

Мал тооллогын хамралт, чанарыг дээшлүүлэх, тооллогын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, түүний ашиглалтыг нэмэгдүүлэх чиглэлд хамтран ажиллах зорилгоор 2014 оны 2 дугаар сарын 7-ны өдөр байгуулсан ҮХААЯ, ҮСХ, МБ-ны хамтран ажиллах санамж бичгийг мөрдөн ажилласан.

4.2. Цаг хугацаандаа байх, шуурхай байдал

Тайлант жилийн мал тооллогын дүнг ҮСХ-ны даргын тушаалаар оны эхэнд батлагдсан графикт хугацаанд хэвлэлийн бага хуралд танилцуулж, улмаар сарын нийгэм, эдийн засгийн байдлын танилцуулгад тусган хэрэглэгчдэд хуваарийн дагуу тогтсон хугацаанд тархааж байна.

Цаг хугацаандаа байх байдлыг хангах үүднээс малтай өрх, ААНБ бүрээр маягт нөхүүлж MS-DOS-ийн орчинд нэгтгэдэг байсныг 2012 оноос эхлэн онлайн системд шилжүүлснээр мэдээллийг цаг хугацаандаа шуурхай боловсруулж, нэгтгэх ажил хялбарчлагдан, мэдээлэл дамжуулах үеийн логик, балансын зэрэг алдаа гарахгүй болсон.

2014 оны мал тооллогын урьдчилсан дүнг 2014 оны 12 дугаар сарын 25нд, харин нэгдсэн дүнг 2014 оны 12 дугаар нийгэм, эдийн засгийн байдлын сарын танилцуулгад аймаг, бүс, улсын түвшинд нийт 15 хүснэгтээр 61 үзүүлэлтийг хэрэглэгчдэд хүргэж, тархаасан байна. /Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал 2014/12/

Энэ хугацаанд тооллогын урьдчилсан болон нэгдсэн дүнгээр товч танилцуулгыг бэлтгэн ҮСХ-ны вэб сайтад байршуулан, хэрэглэгчдэд хүргэлээ.

4.3. Хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байдал

Хэрэглэгчтэй харилцах менежментийг сайжруулах, эргэх холбоотой ажиллах, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээтэй мэдээллийг судлах, статистикийн мэдээллийн хэрэглээний түвшинг тодорхойлох үүднээс хэрэглэгчийн бүртгэлийг программчлан ажиллаж байна. Хэрэглэгчдээс гарсан санал, хүсэлтийн дагуу бүтээгдэхүүний хэлбэр, дизайныг өөрчлөх, нийтэд хүртээмжтэй байх тал дээр байнга анхаарч ажилладаг.

Мал тооллогын мэдээллийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр тархаадаг ба түүнчлэн хэрэглэгчид албан бичгээр болон өөрийн биеэр хандах, хэвлэлийн бага хурал, олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан мэдээлэл авч байгаа болно.

ҮСХ-ны захиалгаар 2012 онд хийгдсэн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны дүнгээс харахад судалгаанд оролцогчдын 37.3 хувь нь ХАА-н статистик мэдээллийг мэддэг, 80.4 хувь нь хэрэглэдэг, 75.6 хувь нь хэрэгцээнд нийцдэг гэсэн нь ХАА-н салбарын том хэсэг болох мал тооллогын мэдээлэл хэрэглэгчдийн хэрэгцээ, шаардлагад нийцдэг болохыг харуулж байна.

2014 оны мал тооллогын дүнг 2015 оны 1 дүгээр сард хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тэдгээрийн дараах бүлэгт буюу “үндсэн” хэрэглэгчдэд тархаасан болно.

- Хүнс, хөдөө аж ахуйн яам;
- Их дээд, сургуулиуд;
- Хэвлэл мэдээллийн агентлаг, телевиз;

2014 оны мал тооллогын дүнг

Хэвлэмэл бүтээгдэхүүнд:

- 2014 оны 12 дугаар сарын танилцуулга;
- ХАА-н салбарын танилцуулга;

Электрон, он-лайн бүтээгдэхүүнд:

- Статистик мэдээллийн систем www.1212.mn-д 2014 оны мэдээллийн шинэчилсэн хувилбараар.
- Монстат болон Ezstat аппликейшины 2014 оны мэдээлэл зэрэг болно.

ҮХААЯ, ҮСХ, МБ-ны хамтран ажиллах санамж бичигт заагдсаны дагуу малын тоог банкны зээлийн үйлчилгээний хөрөнгийн баталгаа болгох зорилгоор мал тооллогын өрхийн нэгдсэн санд зөвхөн малчны өөрийн хүсэлтийн дагуу арилжааны банкууд мэдээллийн санд хандан тухайн өрхийн мэдээллийг харах, лавлагаа болгон авах боломж 2014 оноос эхлэн бий болоод байна.

4.4. Нийтэд хүртээмжтэй, ил тод байдал

ҮСХ нь хувьд бүх хэрэглэгчдийг статистикийн мэдээллээр адил тэгш хангах зарчим баримталдаг бөгөөд хуулийн хүрээнд бүх мэдээлэл хэрэглэгчдэд нээлттэй, ил тод байдаг. Нийтэд хүртээмжтэй, ил тод байдлыг хангахдаа мэдээллийн нууцлалыг чандлан хадгалдаг.

Хэрэглэгчид мал тооллогын мэдээллийг хүснэгтэн, текст, график дүрслэл хэлбэрээр тархахаас гадна статистик мэдээллийн үйлчилгээний нэгдсэн систем МОНСИС – www.1212.mn сайтад байрлуулан нийтэд үнэ төлбөргүйгээр хүргэж байна.

Нөгөө талаас хэрэглэгчид хүртээмжтэй, орон зай цаг хугацаанаас хамаарахгүйгээр хүссэн мэдээллээ авах боломжийг бүрдүүлсэн www.1212.mn вэб сайтын үзүүлэлтүүдийг iPhone, iPad, Android төхөөрөмж ашиглан үзэх боломжтой ezStat аппликейшн, iPhone, iPad, Android төхөөрөмжүүдэд зориулсан статистикийн хэвлэмэл бүтээгдэхүүнийг унших боломжтой Monstat аппликейшн-ыг ашиглан тархааж байна.

4.5. Нийцтэй, харьцуулах боломжтой байдал

Мал тооллогын мэдээллийн сан 1924 оноос эхлэн бүрдээд байна. Үүнд:

- Малын тоо, малын төрлөөр, улсын дүнгээр
- Том малын зүй бус хорогдол, малын төрлөөр, улсын дүнгээр

Мал тооллогын мэдээллийн санд 1971 оноос эхлэн сум, дүүрэг, аймаг, нийслэл, улсын дүнгээр дараах мэдээллүүд байна. Үүнд:

- Малын тоо, малын төрлөөр
- Хээлтэгч малын тоо, малын төрлөөр
- Бойжуулсан төлийн тоо, төл малын төрлөөр
- 100 эхээс бойжуулсан төлийн тоо, төл малын төрлөөр
- Том малын зүй бус хорогдол, малын төрлөөр
- Өвчнөөр хорогдсон малын тоо, малын төрлөөр
- Хээл хаясан хээлтэгч малын тоо, малын төрлөөр
- Сувайрсан хээлтэгч малын тоо, малын төрлөөр
- Малтай өрхийн тоо
- Малчдын тоо
- Гахайн тоо
- Үндсэн мэгжийн тоо
- Шувууны тоо
- Өндөглөгчийн тоо зэрэг болно.

Харин 2012 оноос эхлэн малтай өрх, ААНБ бүрээр “Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллого”-ын маягтын бүхий л мэдээлэл бий болоод байна. Маягтыг хавсралтаас харна уу.

2014 оны мал тооллогын мэдээнд цаг хугацааны болон орон зайн хувьд харьцуулагдахуйц байдал хангагдаж, өмнөх оныхтой харьцуулсан үр дүнг нэгтгэн, тархаасан.

5. Нууцлалыг хангасан байдал

Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн 22-р зүйлийн 7-д “Тооллого, түүвэр судалгаанд хамрагдсан хувь хүн, хуулийн этгээдийн анхдагч мэдээлэлд боловсруулалт хийсний дараа хэрэглэгчдэд ашиглуулж болно. Анхдагч мэдээлэлд боловсруулалт хийж, хэрэглэгчдэд ашиглуулахтай холбогдсон журмыг нууцын тухай хууль тогтоомжид нийцүүлэн Үндэсний статистикийн хорооны дарга батална” гэсэн заалттай.

Мөн “Үндэсний статистикийн хорооны нууцын тухай журам” болон “Тооллого, түүвэр судалгааны анхдагч мэдээллийг хэрэглэгчдэд ашиглуулах журам” зэргийг үндэслэн, гэрээ хийж нууцлалыг хангасан анхдагч мэдээллээр дотоодын болон гадаадын хэрэглэгчдэд ашиглах эрхийг олгодог.

Уг чанарын тайланд дурьдагдсаны дагуу мал тооллогыг ҮСХ-ноос жил бүр уламжлал болгон чанарын өндөр түвшинд зохион байгуулж, үр дүнг цаг хугацаандаа, үнэн зөв, шуурхай, ил тодоор хэрэглэгчдэд хүргэж байгаа болно.

Энэхүү чанарын тайлантай холбогдолтой асууж, тодруулах зүйлээ information@nso.mn хаягаар болон 51-261565 утсаар лавлана уу.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО
МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР

Үндэсний статистикийн хорооны даргын 2014 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн А/103 дугаар тушаалаар батлав.

МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТАД, ХАШАА, ХУДГИЙН 20. . . ОНЫ ТООЛЛОГО

I. Хаягийн хэсэг

1. Байршил					Мэдээллийн нууцыг Монгол Улсын “Байгууллагын нууцын тухай”, “Хувь хүний нууцын тухай” болон “Статистикийн тухай” хуулийн дагуу чандлан хадгална.
1. Аймаг нийслэлийн нэр	Код	<input type="text"/>	<input type="text"/>		
2. Сум, дүүргийн нэр	Код	<input type="text"/>	<input type="text"/>		
3. Баг, хорооны нэр	Код	<input type="text"/>	<input type="text"/>		

2. Өрхийн мэдээлэл								
а. Үндсэн өрхийн мэдээлэл								
4. Өрхийн бүртгэлийн дугаар	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>	9. Ам бүлийн тоо	<input type="text"/>	<input type="text"/>	
5. Өрхийн тэргүүлэгчийн регистрийн дугаар	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>	10. Малчдын тоо	<input type="text"/>	<input type="text"/>	
6. Өрхийн тэргүүлэгчийн эцэг/эхийн нэр					11. Үүнээс: Эмэгтэй	<input type="text"/>	<input type="text"/>	
7. Өрхийн тэргүүлэгчийн нэр					12. Нийт малчид насны бүлгээр:			
8. Өрхийн төрөл					1. 15-34 насны	<input type="text"/>	<input type="text"/>	
Мал бүхий өрх 1	Малчин өрх 2	Бусад өрх 3			2. 35-59 насны	<input type="text"/>	<input type="text"/>	
						3. 60 түүнээс дээш насны	<input type="text"/>	<input type="text"/>
<i>(10-12-р асвулт нь зөвхөн малчин өрхийн хувьд нөхөгдөнө.)</i>								

б. Тавиул малыг эзэмшигч өрхийн мэдээлэл*		<i>(Тавиул малыг эзэмшигч өрхийн мэдээллийг нөхөхдөө маллагчийн өрхийн бүртгэлийн дугаарыг (4) заавал нөхнө.)</i>	
13. Тавиул малыг эзэмшигч өрхийн дугаар	<input type="text"/>	<i>(Тавиул малыг эзэмшигч өрхийг маллагч өрх дотор нь 1-ээс эхлүүлэн дугаарлана.)</i>	
14. Өрхийн тэргүүлэгчийн регистрийн дугаар	<input type="text"/>		
15. Өрхийн тэргүүлэгчийн эцэг/эхийн нэр			
16. Өрхийн тэргүүлэгчийн нэр			
17. Өрхийн төрөл			
Тавиул мал эзэмшигч өрх 4	<i>*(Тавиул малын эзэмшигч өрхийн хувьд зөвхөн 1-4 дүгээр хүснэгт нөхөгдөнө.)</i>		

3. Аж ахуйн нэгж, байгууллагын мэдээлэл						
18. Регистрийн дугаар	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>	24. Малчдын тоо	<input type="text"/>	<input type="text"/>
19. Аж ахуйн нэгж, байгууллагын нэр				25. Үүнээс: Эмэгтэй	<input type="text"/>	<input type="text"/>
20. Үйл ажиллагааны салбарын чиглэл	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>	26. Нийт малчид насны бүлгээр:		
22. Малчин өрхийн тоо	<input type="text"/>	<input type="text"/>		1. 15-34 насны	<input type="text"/>	<input type="text"/>
23. Малчин өрхийн нийт ам бүлийн тоо	<input type="text"/>	<input type="text"/>		2. 35-59 насны	<input type="text"/>	<input type="text"/>
				3. 60 ба түүнээс дээш насны	<input type="text"/>	<input type="text"/>

27. Хариуцлагын хэлбэр

Нэр	Код
Хувьцаат компани	10
Хязгаарлагдмал хариуцлагатай компани	11
Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл	20
Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл	21
Хоршоо	30
Төрийн өмчит үйлдвэрийн газар	40
Орон нутгийн өмчит газар	41
Төсөвт байгууллага	60
Төрийн бус байгууллага	70
Бусад	80

28. Өмчийн хэлбэр

	Нэр		Хувь	Код
	Өмчийн	Хувийн		
Төрийн	өмчийн			11
	өмчийн оролцоотой%		12
	хамтарсан%		13
Хувийн	өмчийн			21
	гадаадтай хамтарсан%		22
	гадаадын			23
Орон нутгийн	өмчийн			30
	өмчийн оролцоотой%		31
	хамтарсан%		32

II. Үндсэн үзүүлэлт

1. Бэлэн тоологдсон мал, нас, хүйсээр

Малын төрөл	м/д	Бүгд	Хээлтүүлэгч	Үүнээс шинээр тавьсан	Энэ жилийн төл		Өнгөрсөн жилийн төл		2 настай		3 настай		4 настай		5 ба түүнээс дээш настай	
					эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм		
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15
Тэмээ	1															
Адуу	2															
Үхэр*	3															
Хонь	4															
Ямаа	5															
Бүгд	6															

* Сарлаг, хайнаг ороод. **Шалгалт:** багана1=багана2+багана(4÷15).

1а. Үхэр, үүнээс:

	М/Д	Бүгд	Үнээ
А	Б	1	2
Сарлаг	7		
Хайнаг	8		

2. Малын тоо толгойн өөрчлөлт

Малын төрөл	м/д	Оны эхэнд тоологдсон малын тоо	Нэмэгдсэн			Хасагдсан							
			Худалдаж авсан	Шилжиж ирсэн	Бэлэн тоологдсон төл	Худалдсан	Шилжүүлсэн	Алдсан, хулгайлагдсан, олодохгүй байгаа	Зах зээлд борлуулсан	Хүнсэнд хэрэглэсэн	Зүй бусаар хорогдсон	Гэнэтийн аюулаар	Өвчнөөр
А	Б	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27
Тэмээ	9												
Адуу	10												
Үхэр	11												
Хонь	12												
Ямаа	13												
Бүгд	14												

Шалгалт: багана1=багана(17+18+19-20-21-22-23-24-25). багана25>багана(26+27).

Тайлбар: 4, 5 дугаар баганын энэ жилийн төлийн тоо 19 дүгээр баганын бэлэн төлийн тоотой тэнцүү байна. Харин бог малын төлийн хувьд 3, 4, 5 дугаар баганын нийлбэр буюу энэ жилийн төл дээр бог малын шинээр тавьсан хээлтүүлэгчийг нэмсэнтэй тэнцүү байна.

3. Төллөх малын тоо толгойн өөрчлөлт

Малын төрөл	м/д	Оны эхний хээлтэгч	Хээлтэй малын тоо		Хээл хаясан	Сувайрсан	Өнжсөн	Төллөсөн
			Нэмэгдсэн	Хасагдсан				
А	Б	28	29	30	31	32	33	34
Ингэ	15							
Гүү	16						×	
Үнээ	17						×	
Эм хонь	18						×	
Эм ямаа	19						×	
Бүгд	20							

Шалгалт: багана(28+29-30-31-32-33)=багана34 ; багана28>багана(31+32) ; багана34=<багана35.

4.Төлийн тоо толгойн өөрчлөлт

Төлийн төрөл	М/Д	Гарсан төл	Хорогдсон төл	Бойжсон төл	Худалдаж авсан	Шилжиж ирсэн	Худалдсан	Шилжүүлсэн	Хүнсэнд хэрэглэсэн	Каракуль арьсанд зориулж нядалсан
А	Б	35	36	37	38	39	40	41	42	43
Ботго	21								×	×
Унага	22								×	×
Тугал	23									×
Хурга	24									
Ишиг	25									×
Бүгд	26									

Шалгалт: багана(35-36)=багана37 ; багана19=багана(37+38+39-40-41-42-43).

5. Нутгийн шилдэг омог, цэвэр үүлдэр, эрлийз, нутгийн сайжруулсан үүлдрийн малын тоо

Үүлдрийн нэр	М/Д	Малын код			Бүгд	Хээлтэгч	Хээлтүүлэгч	Бусад
Нутгийн шилдэг омог	1							
...	2							
...	3							
...	4							
...	5							
...	6							
...	7							
...	8							
Цэвэр үүлдэр	9							
...	10							
...	11							
...	12							
...	13							
...	14							
...	15							
...	16							
Эрлийз	17							
...	18							
...	19							
...	20							
...	21							
...	22							
...	23							
...	24							
...	25							
Нутгийн сайжруулсан үүлдэр	26							
...	27							
...	28							
...	29							
...	30							
...	31							
...	32							
...	33							
...	34							
...	35							
...	36							

Шалгалт: багана1≥багана(1+2)

6. Тэжээвэр амьтад

	М/Д	Бүгд	Хээлтэгч	Хээлтүүлэгч	Бусад
Гахай	1				
Шувуу	2				
Үүнээс: тахиа	3				
Цаа	4				
Илжиг	5				
Булга	6				
Үнэг	7				
Туулай	8				
Минж	9				
Зөгийн бүл	10				

Шалгалт: багана1=багана(2÷4); мөр2 ≥ мөр3

7. Тэжээвэр амьтдын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт

	М/Д	Х/н	Үйлдвэрлэсэн биет хэмжээ	борлуулсан	
				биет хэмжээ	үнэ мян.төг
А	Б	В	1	2	3
Гахайн мах /амьдын жин/	1	кг			
Шувууны мах /амьдын жин/	2	кг			
Өндөг	3	ш			
Цусан эвэр	4	кг			
Булганы арьс	5	ш			
Үнэгний арьс	6	ш			
Туулайн арьс	7	ш			
Туулайн мах	8	ш			
Минжний арьс	9	ш			
Зөгийн бал	10	кг			

Шалгалт: багана1≥багана2

8. Малчин өрхийн ахуйн зарим үзүүлэлт

	М/Д	Цахилгааны эх үүсвэр	Нарны	Салхины	Бага оврын цахилгаан	Төвлөрсөн систем	Бусад	Сансрын антенн	Телевизор	Радио	Оёдлын машин	Гар утас	Гар аргаар хийсэн эсгий, м
Тоо, ш	1												
Хүчин чадал, Квт	2					х		х	х	х	х	х	х

Шалгалт: багана1=багана(2÷6); Тайлбар: Зөвхөн малчин өрхийн хувьд нөхөгдөнө.

9. Бэлтгэсэн тэжээл

	МД	Бэлтгэсэн хадлан (тн)	Таримал тэжээл	Даршны ургамал	Гар тэжээл	Хужир шүү	Төмс, хүнсний ногооны хаягдал	Үр тарианы хаягдал	Лай	Сүрэл
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9
Хэмжээ, кг	1									

10а. ХАА-н үйлдвэрлэлд ажиллаж байгаа мэргэжлийн боловсон хүчин

	М/Д	Тоо
А	Б	1
Малын эмч	1	
Үүнээс: Дээд боловсролтой	2	
Мал зүйч	3	
Үүнээс: Дээд боловсролтой	4	
Агрономич	5	
Үүнээс: Дээд боловсролтой	6	
Механикжуулагч	7	

10б. ХАА-н үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа машин техник

	М/Д	Тоо
А	Б	1
Трактор	8	
Үүнээс: Дугуйт	9	
Үр тарианы комбайн	10	
Төмсний комбайн	11	
Даршны комбайн	12	
Анжис*	13	
Тариа үрлэгч*	14	
Ногоо үрлэгч*	15	
Төмс суулгагч*	16	
Борной*	17	
Бул*	18	
Сийрүүлэгч*	19	
Сэндлэгч*	20	
Бороожуулагч*	21	
Морин хадуур	22	
Ачааны авто машин	23	
Суудлын авто машин	24	
Бусад төрлийн авто машин	25	
Мотоцикл	26	
Цахилгаан станц*	27	
Үнээний саалтуур*	28	
Хонь хяргагч*	29	
Сепаратор (цөцгий ялгагч)*	30	

11. Худаг, усан сан

Үзүүлэлт	М/Д	Бүгд		Бэлчээрт байршдаг*	Ашиглахгүй*
		Тоо	Багтаамж*, м3		
А	Б	1	2	3	4
Худаг, бүгд	1		х		
Гүний өрөмдмөл*	2		х		
Богино яндант*	3		х		
Энгийн уурхайн*	4		х		
Бусад*	5		х		
Усан сан*	6			х	

Шалгалт: мөр1=мөр(2ч5), багана1≥багана3, багана1≥багана4

12. Малын хашаа

Үзүүлэлт	М/Д	Нийт хашаа	Бүгд			Бодын хашаа *
			Дулаан байр*	Саравчтай*	Саравчгүй*	
А	Б	1	2	3	4	5
Тоо	1					
Багтаамж* (хонин толгойд шилжүүлснээр)	2					

Шалгалт: багана1=багана(2ч4), багана1≥багана3, багана1≥багана5

Тайлбар: (*) тэмдэглэгээ хийгдээгүй үзүүлэлтийг жил бүрийн мал тооллого, бусад үзүүлэлтийг 3 жил тутам Малын хашаа, худгийн тооллогод хамруулна.

13. Хоршоо, нөхөрлөл, бүлгийн гишүүн эсэх

Үзүүлэлт	М/Д	Тийм -1, Үгүй-2
Хоршоо	1	
Нөхөрлөл	2	
Малчдын бүлэг	3	
Бэлчээр ашиглалтын хэсгийн гишүүн	4	

Мал тоолуулсан малчны овог нэр.....
гарын үсэг.....

Тоолсон тооллогын комиссын гишүүний овог нэр.....
гарын үсэг.....

20... оны 12-р сарын